

**УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН 2022 оны III УЛИРЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2022 оны 09 дугаар сарын 27

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт
1	2	3	4	5
1.1. “Музейн үндсэн чиглэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж, үзүүлэгийг Улаанбаатар хотын түүхийн судалгааны сүүлийн үеийн үзэл баримтлал, ололтод тулгуурлан, шинэлэг шийдэл, зохимжтойгоор дэглэн нийтийн хүртээл болгоно” зорилтын хүрээнд:				
	Монгол Улсын анхны Ерөнхий сайд Т.Намнансүрэнгийн амьдарч байсан “Гоожингийн өндөр” хэмээх түүхэн дурсгалт хоёр давхар барилгад музей байгуулах үзэл баримтлал, сэдэвчилсэн төлөвлөгөө боловсруулан гаргана.	Боловсруулсан баримт бичгийн тоо	10	Монгол улсын анхны Ерөнхий сайд Т.Намнансүрэнгийн амьдарч байсан “Гоожингийн өндөр” хэмээх түүхэн дурсгалт хоёр давхар барилгын түүхийн судалгааг хийж, Т.Намнансүрэнгийн нэрэмжит “Нийслэл хүрээ” музейн хэрэгцээ, шаардлага, үндэслэл, үзэл баримтлал, Т.Намнансүрэн, С.А.Козин нарын түүх, Нийслэл хүрээний түүхийн хураангуй, музейн үзүүлэгийн сэдэвчилсэн төлөвлөгөө, Т.Намнансүрэн, С.А.Козинтой холбоотой архивын баримт бичиг, эд өлгийн зүйлсийн жагсаалтыг боловсруулж бэлэн болгосон. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-09.30 Биелэлтийн хувь: 100
1.2. “Музей судлал, сан хөмрөгийн үзмэр, Улаанбаатар хотын хөгжлийн түүхийн чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажил явуулна” зорилтын хүрээнд:				
1.2.1	“Монгол Арт” галарейтэй хамтран “Хүрээ хийдийн монгол зураг” төсөл хэрэгжүүлж, “1870-аад оны Их хүрээ хотын монгол	Судалгааны бичвэрийн хуудасны тоо	15	“1870-аад оны Их хүрээ хотын монгол зураг” судалгааны ажлын хүрээнд дараах ажлуудыг хийв. 1. Монголын үндэсний архивт сууж, 18-19 дүгээр зууны Их хүрээний түүхэнд холбогдох баримтуудыг шүүн үзэж, шаардлагатай баримтуудыг хуулбарлан авав.

	зураг номын судалгааны ажлыг хийнэ.			<p>2. Их хүрээ зурагт Хүрээний бүтэц, хэсгийн нэршлийг нарийвчлан бичиж, тэмдэглэв.</p> <p>3. Их хүрээ зурагт дүрслэгдсэн Хүрээний бүтцүүдээс Зүүн хүрээний бүтцийн түүхийг дэлгэрэнгүй бичих ажлыг эхлүүлэв.</p> <p>4. “Хүрээ хийдийн монгол төсөл”-ийн хүрээнд хийсэн судалгааны ажлын тайланг бичиж, Монгол Арт галарейд танилцуулав.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-09.30 Биелэлтийн хувь: 100</p>
1.2.2	“Улаанбаатар мэдээ” сонины 1955-1990 оны дугаараас хотын түүхтэй холбогдолтой шүүн авсан илтгэл, нийтлэлийг цахим хэлбэрт шивж оруулах, агуулгаар төрөлжүүлэн ангилах, үйл явдлын он цагийн хэлхээс гаргах, хэвлэлийн эх бэлтгэх ажлыг зохион байгуулна.	Хэвлүүлэхэд бэлтгэсэн нийтлэлийн тоо	200	<p>“Улаанбаатарын мэдээ” сонины 1955-1990 оны 5250 дугаарын 21,000 гаруй нүүрээс Улаанбаатар хотын түүх, хот байгуулалт, боловсрол, соёл, эрүүл мэнд, гадаад айлчлал, хотын удирдлагуудын илтгэл, нийтлэл, цаг үеийн шинжтэй мэдээ зэрэг Улаанбаатар хотын өдөр тутмын амьдралын түүхийг харуулсан мэдээ, мэдээллийг бүрэн шүүн дуусав. Тэдгээр шүүсэн илтгэл, нийтлэл, мэдээнээс хотын түүхтэй холбогдолтой нийт 310 гаруй нийтлэл, илтгэлүүдийг шивж, цахим хэлбэрт шилжүүлээд байна.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-09.30 Биелэлтийн хувь: 100</p>
1.2.3.	Улаанбаатар хотын иргэдийн дурсамжийн сан үүсгэж, иргэдээс дурсамж сурвалжлан авч баяжуулах ажлыг зохион байгуулна.	Баяжуулсан дурсамжийн тоо	2	<p>Нийслэлийн архив дахь музейн хөмрөгт хадгалагдаж буй 1990-2000 онд иргэдээс авсан 5 дурсамжийг хуулбарлан авч, цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг зохион байгуулав.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-09.30 Биелэлтийн хувь: 100</p>
1.3. “Хүүхэд, залуус, иргэдэд хотын түүх, соёлыг сурталчлан таниулах, нийслэл хотоороо бахархах үзэл санааг төлөвшүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулна” зорилтын хүрээнд:				
1.3.1.	Музейн цахим хуудас, хэвлэл, мэдээллийн	Сурталчилсан дурсгалын тоо	10	2022.07.29-нд news.mn сайтад Дуурь бүжгийн эрдмийн театрын барилгын талаар, 2022.08.30-нд Өрөг.мн сайтад

	хэрэгслээр дамжуулан нийслэлийн түүхэн дурсгалт газар, барилга байгууламж, хөшөө дурсгал, гудамж талбайг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.			Богдын цагаан ордны түүхийн талаар, 2022.08.31-нд Гандан тв-д "Залуу хот судлаач" хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн хийсэн легоны үзэсгэлэнгийн тухай, 2022.09.18-нд News.mn сайтад 1924 оны Улсын анхдугаар их хурлаар Улаанбаатар хот хэмээх нэрийг өгсөн талаар ярилцлага, мэдээлэл өгөв. Мөн 2022.09.02-нд Дүрслэх урлагийн музейн Өндөр хоршоо подкастэд зочноор оролцож, тус музейн барилгын түүх болон Барилгачдын талбайн орчим дахь түүхэн газар, барилгын талаар ярилцаж, одоогийн хадгалалт хамгаалалт, цаашид хэрхэн авч үлдэх, ямар ач холбогдол, үнэ цэнтэй талаар яриу.
				Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-09.30 Биелэлтийн хувь: 100
1.3.2.	Музейгээр үйлчлүүлэгчдэд Улаанбаатар хотын түүх, соёлыг музейн байнгын болон түр үзүүлэгт тулгуурлан тайлбарлан таниулна.	Тайлбар тавьсан үйлчлүүлэгчийн тоо	Нийт үйлчлүүлэгчийн 15 хувь	Нийт 350 үзэгчээс 114 том хүн, 84 оюутан, 21 гадаад хүн, 131 хүүхэд үйлчлүүлсэн. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.05-2022.09.28 Биелэлтийн хувь:100%
1.4. "Үзмэр, эд зүйлийг бүртгэн баримтжуулах, үзлэг тооллого явуулах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохих журмын дагуу хийж гүйцэтгэнэ" зорилтын хүрээнд:				
1.4.1.	Соёлыг өвийн бүртгэн баримтжуулах заарын дагуу RCH бүртгэлийн программд үзмэр, эд өлгийн зүйлийн мэдээллийг бүртгэн оруулах ажлыг зохион байгуулна.	Бүртгэлийн программд оруулсан үзмэрийн тоо	50	Соёлыг өвийн бүртгэн баримтжуулах зааврын дагуу "RCH" программд 50 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг бүртгэн оруулсан. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.30 Биелэлтийн хувь: 100%
1.4.2.	Соёлын өвийн бүртгэлийн маягт №2-оор бүртгэгдсэн музейн үзмэр, эд өлгийн	Цаасан хэлбэрээр	50	Уран зургийн төрлийн үзмэрээс 15 ширхэг, угсаатан зүйн төрлөөс 15 ширхэг, баримт бичгийн төрлөөс 15 ширхэг, сийлбэр, гар урлалын төрлийн 5 ширхэг нийт 50 ширхэг

	зүйлийн мэдээллийг төрөлжүүлэн архивлах	архивласан үзмэрийн тоо		үзмэр, эд өлгийн зүйлийн мэдээллийг төрөлжүүлэн архивлах ажлыг хийлээ. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.30 Биелэлтийн хувь: 100%
1.4.3.	Үзмэр, эд өлгийн зүйлийн хөдөлгөөний актыг цаг тухай бүр гаргаж, үзмэр хөдөлгөөнд оруулахад хяналт тавин ажиллах.	Гаргасан хөдөлгөөний актын тоо	2	1/ Музейн захирлын 2022 оны А/41 дүгээр тушаалыг үндэслэн 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хооронд Монголын Үндэсний музейн үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулагдах Монгол Улсын Ардын зураач, БНМАУ-ын Урлагийн гавьяат зүтгэлтэн Лэгшидийн Чуваамэдийн “Зуун дамжих урлал” уран бүтээлийн үзэсгэлэнд 1 дэсийн 1 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлд бүртгэн баримтжуулах зааврын дагуу “Үзмэр, эд зүйлийг түр гаргах, буцаах акт” №04-г үйлдэж хөдөлгөөнд оруулж хяналт тавин ажилласан. 2/ Тайлант хугацаанд эрдэм шинжилгээний ажилтан О.Одсүрэн “Үзмэр эд өлгийн зүйл, холбогдох баримт бичигтэй танилцах өргөдөл” гаргасныг үндэслэн “Музей дотор үзмэр, эд өлгийн зүйл хүлээлцсэн акт” №07-г үйлдэн бичиг баримтын төрлийн 1 дэсийн 1 ширхэг үзмэрийг хүлээлгэн өгч, буцааж авах ажлыг сан хөмрөгчтэй хамтран зохион байгуулав. Тайлант хугацаанд музейгээс түр гаргах, буцаах акт болон музейн дотор хүлээлцэх акт тус бүр нэг нэгийг үйлдэн нийт 2 дэсийн 2 ширхэг үзмэр, эд өлгийн зүйл хөдөлгөөнд орсон байна. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.30 Биелэлтийн хувь: 100%
1.4.4.	Сан хөмрөгчийн ажил хүлээлцэх ажлыг зохион байгуулж, ажил хүлээлцсэн акт үйлдэх	Гаргасан актын тоо	1	Музейн захирлын 2022 оны А/42 дугаар тушаалаар сан хөмрөгчийн ажил хүлээлцэх комиссыг Б.Нарангэрэл, Ч.Өсөхжаргал, Г.Очбаяр, О.Одсүрэн, Д.Гантулга нарын бүрэлдэхүүнтэй байгуулан, 2022 оны 07 дугаар сарын 01-нээс 07 дугаар сарын 22-ны хооронд сан хөмрөгч П.Ариунаагаас боловсролын ажилтан Б.Төгсжаргалд 784

				дэсийн 3429 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг нэг бүрчлэн хүлээлгэн өгч, ажил хүлээлцсэн актыг холбогдох заавар журмын дагуу үйлдэв. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.07.30 Биелэлтийн хувь: 100%
1.4.5.	Музейн байнгын үзүүллэгийн танхим дахь үзмэрийн бүртгэл хөтөлж, хянуулна.	Хөтөлсөн бүртгэлийн тоо	1	БНМАУ мандтугай сийлбэр 06-р сарын 28-нд үзэсгэлэнд явж 08-р сарын 03-нд бүртгэл мэдээллийн санчтай хамтран хүлээн авч үзмэрийн бүртгэлээ хөтөлж хянуулсан. Эхэлсэн, дууссан огноо: 2022.08.03
1.4.6.	Музейн үзүүллэгийн танхимын түлхүүр болон витринд дэглэгдсэн үзмэрүүдийн лацыг шалгаж хяналт тавина.	Жижүүрт хүлээлгэн өгсөн лац бүртгэлийн тоо	61	Музейн үзүүллэгийн танхим дахь витриний лацыг 7 хоногийн ажлын 5 өдөр шалгаж тухайн өдрийн жижүүрт хүлээлгэн өгөхдөө бүртгэлээ нийт 61 удаа хөтөлсөн. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.05-2022.09.30 Биелэлтийн хувь: 100%
1.4.7.	Музейн үзүүллэгийн танхимын чийг дулааныг хэмжиж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.	Хэмжилт хийсэн бүртгэлийн тоо	61	Музейн үзүүллэгийн танхим дахь чийг дулааныг 7 хоногийн ажлын 5 өдөр шалгаж дотор болон гаднах дулаан, чийгшлийг хэмжиж бүртгэлээ нийт 61 удаа хөтөлсөн. Мөн шаардлагатай тохиолдолд шилэнд ус хийж тавих, чийгшүүлэгч асаах зэрэг арга хэмжээг авсан. Музейн үзүүллэгийн танхим дахь 2-р хоргонд арслан зааны дунд чөмөгний яс, шүд, сүүжний ясны хэсэг болон савгат хирсийн гавлын яс хадгалагддаг. Уг үзмэрийн материал нь яс тиймээс харьцангуй чийг бага болон их байх үед хатаж хугарах, хөөн тэлж хөгцрөх аюултай. Тийм учраас харьцангуй чийгшлийг тогтмол хянах зорилгоор хоргоны хажууд нэмэлтээр чийгшил хэмжигч байршуулсан. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.05-2022.09.30 Биелэлтийн хувь: 100%
1.4.8.	Сан хөмрөгт хадгалагдаж буй үзмэрүүдийн арчилгаа цэвэрлэгээг хуваарийн	Цэвэрлэгээ хийсэн бүртгэлийн тоо	13	Музейн сан хөмрөгт хадгалагдаж буй үзмэрүүдийн арчилгаа, цэвэрлэгээг 2 долоо хоногт нэг удаа хийнэ гэж төлөвсний дагуу нийт 8 удаа цэвэрлэсэн. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.05-2022.09.30

	дагуу сан хөмрөгчтэй хамтран хийнэ.			Биелэлтийн хувь:100%
1.4.9.	Музейн үзмэрийн аюулгүй байдлыг хангаж, музейгээр үйлчлүүлэгчдэд зөвлөгөө, анхааруулга өгч, хяналт тавина.	Музейд үйлчлүүлсэн үзэгчдийн тоо	-	Нийт 350 үзэгч орсон ба үзэгчид музейг үзэж байх үед үзүүллэгийн танхим дахь үзмэрийн аюулын байдлыг хянасан. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.05-2022.09.30 Биелэлтийн хувь:100%
1.4.10.	Музейн үзүүллэгийн танхим дахь үзмэрийн цэвэрлэгээг хуваарийн дагуу зохион байгуулна.	Цэвэрлэгээ хийсэн бүртгэлийн тоо	3	Сард нэг удаа зохион байгуулагддаг музейн үзүүллэгийн танхим дахь үзмэрийн цэвэрлэгээг сан хөмрөгч Б.Төгсжаргал, тайлбарлагч Д.Дэлгэрмөрөн нартай хамтран төлөвлөсний дагуу нийт 3 удаа хийсэн болно. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.05-2022.09.30 Биелэлтийн хувь: 100%
1.4.11.	Музейн үзүүллэгийн танхим дахь туслах хэрэглэгдэхүүнийг /хорго, тавиур, уран зургийн төрлийн үзмэрийн хүрээ/ хуваарийн дагуу цэвэрлэнэ.	Цэвэрлэгээ хийсэн бүртгэлийн тоо	13	Музейн үзүүллэгийн танхим дахь уран зургийн төрлийн үзмэрийн хүрээ болон туслах хэрэглэгдэхүүнийг 2 долоо хоногт нэг удаа цэвэрлэнэ гэж төлөвлөсний дагуу нийт 13 удаа цэвэрлэсэн. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.05-2022.09.30 Биелэлтийн хувь: 100%
1.5. Сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд				
1.5.1.	Сан хөмрөг дэх гэрэл зургийн төрлийн үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах	Үзмэрийн хадгалалтын нөхцөлийг дээшлүүлсэн үзмэрийн тоо	5	Музейн ерөнхий бүртгэлийн гэрэл зургийн төрлийн 1 дэсийн 40 ширхэг үзмэрийн хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулж хуудас бүрд шүлтгүй цаасаар хамгаалалт хийсэн. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.30 Биелэлтийн хувь: 100%
1.5.2.	Музейн сан хөмрөгийн үзмэрийн хадгалалтын нөхцөлийг сайжруулах, эрсдлээс хамгаалах ажлыг зохион байгуулна.	Үзмэрийн хадгалалтын нөхцөлийг дээшлүүлсэн үзмэрийн тоо	5	Уран зургийн төрлийн овор хэмжээ их үзмэрийг зөөж тээвэрлэх, тоос шорооноос хамгаалах зориулалтаар 5 дэсийн 5 ширхэг үзмэрийг ямбуу даавуугаар хамгаалах уут хийсэн.

				Музейн хадгалалтын нөхцөлийг сайжруулж эрсдлээс хамгаалах ажлын хүрээнд музейн үзүүллэгийн танхимд 5 ширхэг, сан хөмрөгийн өрөөнд 1 ширхэг, контор-1 өрөөнд 1 ширхэг, контор-2 өрөөнд 1 ширхэг, жижүүрийн өрөөнд 1 ширхэг галын хорыг байрлуулсан. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.30 Биелэлтийн хувь: 100%
1.5.3.	Музейн сан хөмрөгийн өрөөний үзмэрийн арчилгаа цэвэрлэгээг хувиарын дагуу тогтмол хийх	Цэвэрлэгээ хийсэн тоо	10	Музейн сан хөмрөгийн өрөөний чийгтэй болон хуурай цэвэрлэгээг тогтсон хувиарын дагуу нийт 8 удаа хийж гүйцэтгэсэн. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.30 Биелэлтийн хувь: 100%
1.5.4.	Музейн сан хөмрөгийн өрөөний чийг дулааныг хувиарын дагуу тогтмол хэмжих	Чийг дулаан хэмжсэн тоо	20	Музейн сан хөмрөгийн өрөөний чийг дулааныг хувиарын дагуу тогтмол хэмжиж хүйтэн өдөр чийгшилийг буруулахын тулд 2-3 цаг нь залгаж, дулаан өдөр чийгшилийг нэмэгдүүлэхийн тулд чийгшүүлэгч залгаж саванд ус хийж тавьсан. Чийгшил дулааныг нийт 15 удаа хэмжиж бүртгэсэн. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.30 Биелэлтийн хувь: 100%
1.5.5.	Музейн дүрэм журам зааврын дагуу акт, бүртгэл маягыг хөтлөх	Бүртгэл хөтөлсөн маягтын тоо	3	Музейн дүрэм журам зааврын дагуу хөтлөгдөх чийг дулааны бүртгэл, сан хөмрөгт орсон гарсан хүмүүсийн бүртгэл, сан хөмрөгийн түлхүүр хүлээлцэх бүртгэлийг бүртгэн баримтжуулан ажилсаарбайна. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.30 Биелэлтийн хувь: 100%
1.6. "Музейн цуглуулгын каталог, шинжлэх ухааны болон олон нийтэд зориулсан ном, хэвлэл бэлтгэн нийтэлнэ" зорилтын хүрээнд:				
1.6.1. "Музей нь өөрийн цахим хуудастай байна. Цахим хуудсанд музейн эрхэм зорилго, байгууллагын бүтэц, үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм журам, музейгээс зохион байгуулагдаж байгаа үзэсгэлэнгийн мэдээ мэдээлэл, санхүүжилт, төлбөр хураамж, санал, хүсэлт, өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэсэн дэлгэрэнгүй мэдээллийг байршуулан эргэх холбоог хангаж ажиллана" зорилтын хүрээнд:				

1.6.1.1	Музейгээс зохион байгуулсан арга хэмжээнүүдийг олон нийтийн цахим сувгуудаар /инстаграм, фэйсбүүк стори/ дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Цахим хуудаст оруулсан мэдээллийн тоо	-	<p>Улаанбаатар хотын музейн инстаграм хаягт Улаанбаатар хотын үл хөдлөх түүхэн дурсгалт барилгууд болон үзмэрийн нэгдүгээр танхим дахь легогоор хийсэн барилгуудын зургаар бичлэг хийж пост, стори хэлбэрээр оруулсан.</p> <ul style="list-style-type: none"> - 08-р сарын 26-нд гэр өргөө ТББ-аас санаачилж Улаанбаатар хотын музейтэй хамтран “Залуу хот судлаач” боловсролын хөтөлбөрийн хүрээнд ЕБС-ийн сурагчдын легогоор хийсэн Улаанбаатар хотын түүхэн дурсгалт барилгуудын зургаар тик ток хийж инстаграм болон фэйсбүүкд пост оруулсан - 09-р сарын 12-нд “Үндэсний номын сангийн” тухай пост оруулсан. - 09-р сарын 14-нд “Ажилчин анги цуврал ханын мозайкийн” тухай пост оруулсан. - 09-р сарын 21-нд “Монгол дахь олон улсын нисэх буудлын анхны байшингийн” тухай пост оруулсан. <p>Нийт 4 постноос 3 зураг 1 бичлэг оруулсан. Тэмдэглэлт өдрүүд, үйл ажиллагаатай холбоотой 8 сториг фэйсбүүк болон инстаграмд оруулсан.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.05-2022.09.27 Биелэлтийн хувь: 100%</p>
1.6.1.2	Музейн бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, иргэдэд түүх, соёлыг сурталчлан таниулах зорилгоор “Нийслэл хүрээ” хөлөгт тоглоомын II цуврал “Социалист Улаанбаатар” хөлөгт тоглоомыг бүтээх ажлыг хэрэгжүүлнэ.	Хэвлүүлсэн хөлөгт тоглоомын тоо	50	<p>Улаанбаатар хотын түүхийг хүүхэд багачуудад таниулах танин мэдэхүйн “Социалист Улаанбаатар” хөлөгт тоглоомын дүрүүдийн эскизийг Азука комиксоос хүлээн авч, тоглоомын ерөнхий бүтэц болон дүрэм тогтоох, барилгуудын түүхийг шивэх зэрэг ажилд оролцож тоглоомын эскизийг эх бэлтгэгчид хүлээлгэн өгөв.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.05-2022.09.27 Биелэлтийн хувь: 100%</p>

1.6.1.3	Улаанбаатар мэдээ сонинг хэвлүүлэхэд бэлтгэж, шивэх ажлыг хийнэ.	Шивсэн нийтлэлийн тоо	30	Музейгээс эрхлэн гаргах Улаанбаатар мэдээ сонинг хэвлүүлэхэд бэлтгэж, шивэх ажлыг хийж гүйцэтгэсэн Эхэлсэн, дууссан огноо: 2022. 08.25-09.25
1.6.1.4	2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг боловсруулан бэлтгэж Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэст баталгаажуулж, хүргүүлэх	Хуулийн хугацаанд тайлан гаргаж хүргүүлсэн	1	Музейн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж, хугацаанд нь хүргэж өгч, Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтнээр, хянуулж баталгаажуулсан. Биелэлтийн хувь: 100%
1.6.1.5	2022 оны 2-улирлын ХХОАТ-ын тайланг цахим татварын системд боловсруулж, харьяа Татварын албанд тоон гарын үсгээр цахимаар илгээх	Хуулийн хугацаанд тайлан гаргасан	1	Музейн 2022 оны 2-р улирлын ХХОАТ-ын тайланг боловсруулж, татварын нэгдсэн цахим системд оруулан, тоон гарын үсгээр илгээж, баталгаажуулсан. Биелэлтийн хувь: 100%
1.6.1.6	2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөлөлийг холбогдох эдийн засгийн тооцоо, судалгаанд үндэслэн холбогдох маягтуудын дагуу бэлтгэж, Нийслэлийн Засаг Даргын Тамгын газарт цахимаар болон цаасаар баталгаажуулан хүргүүлэх	Хуулийн хугацаанд төсвийн төсөл боловсруулж хүргүүлсэн	1	Музейн 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөллийг боловсруулж нэгтгэн саналаа Нийслэлийн Засаг даргын Тамгын Газарт цахимаар болон цаасаар баталгаажуулж хүргүүлсэн. 2023 оны төсвийн төслийг 549,415.0 мянган төгрөгөөр, 2024-2025 оны төсвийн төсөөлөлийг 531,019.5 мянган төгрөгөөр тус тус төсөвлөсөн.
1.6.1.7	Албан хэрэг хөтлөлтийн журмыг баримтлан, хариуцсан ажлын чиглэлээр хөтлөх хэргийн нэрийн жагсаалт гарган батлуулж, санхүүгийн	Боловсруулсан баримт бичгийн тоо	5	2022 оны эхний хагас жилийн санхүүгийн баримтуудыг боловсруулан архивын хууль тогтоомж, зааврын дагуу үдэж хавтаслав. Биелэлтийн хувь: 100%

	баримтыг стандартын дагуу архивын бүрдүүлэлт хийж, үдэж хавтаслах			
1.6.1.8	2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг гаргаж, Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэс, "Гроут финанс аудит" ХХК-д зөвлөмжийн биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх	Хуулийн хугацаанд хүргүүлсэн	1	2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг гаргаж, 2022 оны 09 сарын 15-ны өдөр цахимаар Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст илгээсэн. Биелэлтийн хувь: 100%
1.6.1.9	Соёл урлагын байгууллагын хөрөнгө, санхүүгийн бүртгэл тайлан, захиргааны статистикийн мэдээллийг гаргаж, Нийслэлийн соёл урлагын газарт цахимаар илгээх	Хуулийн хугацаанд цахимаар илгээсэн	1	Музейн үйл ажиллагааны 3-р улирлын статистик мэдээ, судалгааг гаргаж, НСУГазарт 09 сарын 19-ны өдөр цахимаар илгээв.
1.7.5.	Өргөдөл гомдлын бүртгэл, шийдвэрлэлтэд анхаарч ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт	Зааврын дагуу хөтлөн явуулна.	EDOC системд нийт 19 өргөдөл бүртгэж, холбогдох мэргэжилтнээр шийдвэрлүүлсэн байна. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.27 Биелэлтийн хувь: 100%
2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал				
2.1.	Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан байх	Сул орон тооны мэдээллийг нээлттэй зарласан мэдээллийн хэрэгслийн тоо	2	Тайлант хугацаанд музейн боловсролын ажилтан, арга зүйч гэсэн 2 ажлын байрны зарыг Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, дүүргүүдийн хөдөлмөрийн бирж, музейн вэб сайт, "Сайн уу Улаанбаатар минь фэйсбүүкээр 2022 оны 05 дугаар сарын 20-ноос өдрөөс эхлэн зарласан. 2022 оны 09 сард боловсролын ажилтны ажлын байранд сонгон шалгаруулалт хийж,

				иргэн Г.Төгсжаргалтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилд авсан. Музейн арга зүйчийн ажлын байранд ажил горилогчийн 3 анкет ирсэн боловч бүгд анкетаа эргүүлэн татаж, өөр ажилд орсон гэсэн хариу өгсөн. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.30 Биелэлтийн хувь: 100%
2.2.	Албан хаагчдын хөдөлмөрийн гэрээг баталгаажуулах ажлыг зохион байгуулах	Боловсруулсан баримт бичгийн тоо	2	Сан хөмрөгч Б.Төгсжаргал, боловсролын ажилтан Г.Төгсжаргал нартай байгуулах хөдөлмөрийн гэрээний төслийг боловсруулж, баталгаажуулах ажлыг зохион байгуулсан. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.25-2022.09.05 Биелэлтийн хувь: 100%
2.3.	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын дагуу “Албан тушаалын тодорхойлолт”-ыг шинэчлэх ажлыг зохион байгуулах	Боловсруулсан баримт бичгийн тоо	15	Музейн захирлын 2022 оны А/25 дугаар тушаалаар албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсэгт орон ажилласан бөгөөд 15 албан тушаалын тодорхойлолт боловсруулалтыг хийж, музейн захирлын дэргэдэх Захиргааны зөвлөлийн 2022 оны 08 дугаар хурлаар хэлэлцүүлж, батлуулсан. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.07.20 Биелэлтийн хувь: 100%
3. Музейн батлагдсан төсөв санхүү зарцуулалт, тайлагналтай холбоотой ажлын хүрээнд:				
3.1.	Батлагдсан төсвийн хуваарийн дагуу өдөр тутмын мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг Нийслэлийн санхүү, төрийн сангийн ажилтнаар хянуулан зарцуулах	Төсөв, гүйцэтгэл, зарцуулалт хийгдсэн.	Өдөр тутам	Батлагдсан төсвийн хуваарийн дагуу өдөр тутмын мөнгөн хөрөнгийн гүйлгээг зохих эдийн засгийн ангилалаар зориулалтын дагуу анхан шатны баримтыг үндэслэн хийж, Нийслэлийн санхүү, төрийн сангаар зарлагын гүйлгээг хянуулан гаргаж зарцуулсан.
3.2.	Сар бүр батлагдсан төсвийг зориулалт тус бүрээр зарцуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээ,	Боловсруулсан баримт бичгийн тоо	Сар бүр	Музейн 2022 оны 6, 7, 8-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, орлогын болон өр авлагын дэлгэрэнгүй мэдээ,

	<p>тайланг гаргаж, Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэх</p>			<p>тайланг сар бүр гаргаж, Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэст хүргэн хянуулан баталгаажуулсан. Батлагдсан төсөв 3-р улиралд өссөн дүнгээр: 290,662.8 мян. төгрөг Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төсвөөс санхүүжих -288,367.8 мян.төгрөг 2. Үндсэн үйл ажиллагааны орлого- 2,295.0 мян.төгрөг <p>Гүйцэтгэл : 290,388.3 мянган төгрөг</p> <ol style="list-style-type: none"> 1. Төсвөөс урсгал санхүүжилт – 288,367.8 мян.төгрөг 2. Үндсэн үйл ажиллагааны орлого-2,020.5 мян.төгрөг <p>Нийт зарлагын дүн: 245,925.3 мян.төгрөг</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Цалин хөлс болон нэмэгдэл урамшил – 190,968.7 мян.төгрөг 2. НДШ /АО/ -24,226.9 мян.төгрөг 3. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал -4,139.2 мян.төгрөг 4. Хангамж, бараа материалын зардал -6,318.0 мян.төгрөг 5. Багаж, техник хэрэгсэл худалдаж авсан зардал – 7,177.4 мян.төгрөг 6. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж -2,570.7 мян.төгрөг 7. Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох – 2,600.0 мян.төгрөг 8. Газрын төлбөр -290.6 мян.төгрөг 9. Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал – 6,183.8 мян.төгрөг 10. Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал – 1,450.0 мян.төгрөг
--	--	--	--	---

3.3.	Ажилчдын цалинг сард хоёр удаа тогтмол бодож тушаал шийдвэр, батлагдсан төсөвт багтаан олгох	Төрийн албаны ЦНСистемд боловсруулалт хийгдсэн.	Сар бүрийн 8, 23 өдөр	Музейн нийт ажилтан, албан хаагчдын 2022 оны 7, 8, 9-р сарын цалинг Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр боловсруулж, тооцон тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар гүйлгээ хийгдсэн. 3-р улиралд өссөн дүнгээр 190,968.7 мян.төгрөгийн цалин, хөлс болон нэмэгдэл, унаа хоолны хөнгөлөлт, үр дүнгийн урамшуулал олгогдсон. Биелэлтийн хувь: 100%
3.4.	Бодогдсон цалингийн дагуу Нийгмийн даатгалын тайланг боловсруулж холбогдох байгууллагад цахимаар болон цаасаар хүргүүлж баталгаажуулах	Хуулийн хугацаанд боловсруулсан баримт бичиг	Сар бүрийн 05-ны дотор	Музейн ажилтан, албан хаагчдын НД-ын шимтгэл төлөлтийн 2022 оны 6, 7, 8-р сарын тайланг гаргаж, харьяа дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст хугацаанд нь хүргүүлж, баталгаажуулсан. Биелэлтийн хувь: 100%
3.5.	2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг Сангийн яамны цахим э-тайланд шивж илгээн Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтсээр хянуулж, баталгаажуулах	Хуулийн хугацаанд э-тайланд шивж илгээх	7 сарын 18	Эхний хагас жилийн санхүүгийн тайланг Сангийн яамны төсвийн байгууллагын э-тайланд шивж оруулан илгээж, Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтсээр хянуулж, баталгаажуулсан. Биелэлтийн хувь: 100%
3.1. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, зарцуулалтыг сайжруулах ажлын хүрээнд:				
3.1.1.	Музейн үндсэн үйл ажиллагааны үзвэрийн орлого бүрдүүлэлтэд хяналт тавьж билетийг дугаарлан, няравтай сарын эцэст тооцоог тулган баталгаажуулах	Тооцоог хянаж, баталгаажуулсан	1	Музейн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 2,295.0 мян.төгрөг Гүйцэтгэл 2,020.5 мян.төгрөг, орлогын төлөвлөгөө 88.0 % биелсэн үзүүлэлттэй. Үзвэрийн орлого бүрдүүлэлтэд хяналт тавьж, билетийг дугаарлан няравтай сарын эцэст тооцоог тулган баталгаажуулан ажилласан. Биелэлтийн хувь: 100%

3.1.2.	Бараа материалын тайланг хянан тулган баталгаажуулж, материалын орлого, зарлагыг хууль, журмын дагуу бүртгэлд тусгах	Тооцоог хянаж, тулган баталгаажуулсан	Сар бүр	Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тайланг гаргаж, няравын бүртгэсэн материалын орлого, зарлагад хяналт тавьж, ерөнхий журнал болон тохируулах бичилт хийж данс тооцоог бүртгэсэн. Биелэлтийн хувь: 100%
3.1.3.	Актлах саналтай эд хөрөнгийн жагсаалт гарган бэлтгэж, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж, шийдвэрлүүлэн саналаа Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлэх	Боловсруулсан баримт бичиг	1	Актлуулж данснаас хасах шаардлагатай 18 нэрийн 26 ширхэг 21,373.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 19 нэр төрлийн 26 ширхэг 5,604.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 8 нэр төрлийн 15 ширхэг 2,942.0 мянган төгрөгийн түүх соёлын дурсгалт зүйлсийн туслах хэрэглэгдэхүүнийг актлуулахаар, 3 нэр төрлийн 11 ширхэг 1,480.0 мянган төгрөгийн хөрөнгийг тавилга эд хогшлын дансруу 1 нэрийн 2 ширхэг 10.0 мянган төгрөгийн эд хөрөнгийг эргэлтийн хөрөнгийн дансруу шилжүүлэхээр тус тус саналаа Нийслэлийн Өмчийн харилцааны газарт захирлын 2022 оны 09 сарын 09-ны өдрийн 109 тоот албан бичгээр хүргүүлсэн.
3.1.4.	Түүх, соёлын дурсгалт зүйлсэд бүртгэлтэй үзмэрийн туслах хэрэглэгдэхүүнийг актлуулах, данснаас дансанд шилжүүлэхэд нэмэлт материал бүрдүүлэх (дээрх эд хөрөнгө нь соёлын өвд хамааралгүйг батлуулахаар Соёлын өвийн Үндэсний төвд хүсэлт гаргах)	Боловсруулсан баримт бичиг	1	12 нэр төрлийн 28 ширхэг 4,432.0 мянган төгрөгийн түүх соёлын дурсгалт зүйлсийн туслах хэрэглэгдэхүүн нь түүх, соёлын дурсгалт зүйлсэд хамааралгүй, үзмэрийн туслах хэрэглэгдэхүүн болохыг баталгаажуулахаар Соёлын өвийн Үндэсний төврүү захирлын 2022 оны 09 сарын 15-ны өдрийн 110 тоот албан бичгээр хүсэлт тавьсан. Соёлын өвийн үндэсний төвийн 2022 оны 09 сарын 21-ны өдрийн 01/338 тоот албан бичгийн хариуг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт захирлын 2022 оны 09 сарын 23-ны өдрийн 112 тоот албан бичгээр хүргүүлсэн.

3.1.5.	Байгууллагын эргэлтийн хөрөнгийг бүрэн хаягжуулах ажлыг хийж гүйцэтгэх	Хаягжуулсан хөрөнгийн тоо	16	Байгууллагын эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 13 нэр төрлийн 16 ширхэг 1,070,453 төгрөгийн хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулж, бүх хөрөнгийг бүрэн коджуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Эхэлсэн, дууссан огноо: 2022.09.01- 2022.09.15 Биелэлтийн хувь: 100%
3.1.6.	Музейн номын сан дахь номын бүртгэлийг хөтлөх	Бүртгэл хөтөлсөн тоо	7	Музейн номын сан дахь номоор дараах хүмүүс үйлчлүүлсэн байна. 1. 2022 оны 07 дугаар сарын 06 -ний өдөр эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаярт 5 ширхэг номыг хүлээлгэн өгсөн. 2022 оны 07 дугаар сарын 06 -ний өдөр нягтлан бодогч Ж.Мөнхтуяад 2 ширхэг номыг тус тус хүлээлгэн өгсөн байна.
3.1.7.	Байгууллагын үндсэн болон бараа материалын тайланг тогтоосон хугацаанд боловсруулж өгөх	Боловсруулсан баримтын тоо	4	Гуравдугаар улиралд дараах тайлангуудыг захирал болон нягтлан бодогчоор хянуулан баталгаажуулсан. 1.Үндсэн хөрөнгийн тайланг улирал бүр 2.Мөнгөн гүйлгээний тайланг сар бүрийн эцэст боловсруулан гаргасан. 3. Үзвэрийн тооцоо бодсон актыг сар бүрийн эцэст боловсруулан гаргасан. 4. Бараа материалын тайланг улирал бүр тус тус цаг хугацаанд нь боловсруулан гаргасан.
3.1.8.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь	Тогтоол шийдвэр, төлөвлөгөөний хэрэгжилтийн тоо	2	1.Гуравдугаар улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, 2. Гуравдугаар улирлын гүйцэтгэлийн тайлан зэргийг 3. 14 хоногийн тайлан 4.Музейн хадгалалт, хамгаалалтын цэвэрлэгээний материалын жагсаалт гаргаж,батлуулсан. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.20 Биелэлтийн хувь: 100%

	гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ.			
3.1.9.	Музейн тасалбарын тооцоог хариуцан, тасалбарыг дугаарлаж нягтлан бодогчоор баталгаажуулан үзмэр хянагчид хүлээлгэн өгөх	Тасалбарын тоо	890	Музейн үзмэр хянагч Л.Одмаад өссөн дүнгээр том хүний тасалбар – 567 ширхэг, оюутны тасалбар – 323 ширхэг, нийт 890 ширхэг тасалбарыг шинээр дугаарлаж, нягтлан бодогчоор баталгаажуулан олгосон. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.20 Биелэлтийн хувь: 100%
3.1.10.	Музейн үндсэн үйл ажиллагааны орлогыг үзмэр хянагчаас хүлээн авч, тухай бүрт холбогдох дансанд хийж, баримтжуулах	Баримтын тоо	34	Тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны орлогыг цаг хугацаанд нь хүлээн авч, өссөн дүнгээр том хүний тасалбар – 529 ширхэг, оюутны тасалбар 289 ширхэг нийт 767 ширхэг тасалбар борлуулагдаж, нийт үзвэрийн орлого 2,020,500 төгрөгийг цаг хугацаанд нь хүлээн авч төрийн сангийн 100200035010 тоот дансанд тушаан баримтжуулж, бүртгэлийг үнэн зөв хөтөлсөн. Сар бүрийн эцэст үзвэрийн тооцоо бодсон актыг тухайн сард борлуулсан тасалбарын угийн хамт баримтжуулан, нягтлан бодогчоор хянуулсан. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.26 Биелэлтийн хувь: 100%
3.1.11	Байгууллагад шаардлагатай бараа материалын орлого болон зарлагыг АСОЛОУС программд бүртгэх	Баримтын тоо	27	Гуравдугаар улирлын байдлаар эргэлтийн хөрөнгийн дансанд бичиг хэргийн дансанд 690,000 төгрөг, бусад материалын дансанд 540,050 төгрөг, нийт 1,230,050 төгрөгийн материалыг шинээр худалдан авч, анхан шатны баримтуудыг бүрдүүлэн хавсаргаж, хөрөнгө тус бүрийг шалгаж хүлээн авч, санхүүгийн программд орлогын 6 ширхэг, зарлагын 21 ширхэг баримтыг боловсруулан гаргасан. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.20 Биелэлтийн хувь: 100%

3.1.12.	Бичиг хэрэг болон цэвэрлэгээ үйлчилгээнд шаардагдах материалыг сар бүрийн эхэнд хуваарийн дагуу олгох, бүртгэх ажлыг хариуцах	Олгосон баримтын тоо	21	Музейн ажилтан, албан хаагчдад бичиг хэргийн материалын зардалд – 311,750 төгрөг, цэвэрлэгээ үйлчилгээнд – 141,517 төгрөг, барилгын засварт – 90,000 төгрөг, бусад хангамжинд – 73,110 төгрөгийн үнэ бүхий материалуудыг анхан шатны баримтын дагуу үйлдэж, захирал болон нягтлан бодогчоор баталгаажуулан бараа материалын олголтыг хийж, санхүүгийн бүртгэлийг цаг хугацаанд нь хөтөлсөн. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.20 Биелэлтийн хувь: 100%
4. Төсөв, санхүүгийн ил тод байдлын хүрээнд:				
4.1.	Тухай бүр оруулах мэдээ, мэдээллийг шилэн дансанд байршуулах	Хуулийн хугацаанд мэдээлсэн	8	Мэдээ, мэдээллийг шилэн дансанд бүрэн байршуулсан. Хугацаа хоцорсон мэдээ, мэдээлэл байхгүй. Биелэлт: 100%
4.2.	Байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл болон бусад сар бүр оруулах мэдээ, мэдээллийг шилэн дансанд байршуулах	Хуулийн хугацаанд мэдээлсэн	3	Мэдээ, мэдээллийг шилэн дансанд бүрэн байршуулсан. Хугацаа хоцорсон мэдээ, мэдээлэл байхгүй. Биелэлт: 100%
4.3.	5 саяас дээшх орлого, зарлагын мөнгөн гүйлгээ гарсан тохиолдол бүрт шилэн дансанд байршуулах	Хуулийн хугацаанд мэдээлсэн	1	Мэдээ, мэдээллийг шилэн дансанд бүрэн байршуулсан. Хугацаа хоцорсон мэдээ, мэдээлэл байхгүй. Биелэлт: 100%
4.4.	Хагас жилээр оруулах мэдээлэл (2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, батлагдсан төсөв гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлт, гм)	Хуулийн хугацаанд мэдээлсэн	4	Мэдээ, мэдээллийг шилэн дансанд бүрэн байршуулсан. Хугацаа хоцорсон мэдээ, мэдээлэл байхгүй. Биелэлт: 100%

4.5.	Улирал бүр оруулах мэдээлэл (батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбар)	Хуулийн хугацаанд мэдээлсэн	1	Мэдээ, мэдээллийг шилэн дансанд бүрэн байршуулсан. Хугацаа хоцорсон мэдээ, мэдээлэл байхгүй. Биелэлт: 100%
4.6.	Музейн 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөлөлийг шилэн дансанд байршуулах	Хуулийн хугацаанд мэдээлсэн	1	Мэдээ, мэдээллийг шилэн дансанд бүрэн байршуулсан. Хугацаа хоцорсон мэдээ, мэдээлэл байхгүй. Биелэлт: 100%
5. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд				
5.1.Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ				
5.1.1.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.	Боловсруулсан баримт бичгийн тоо	1	Тайлант хугацаанд Олон улсын “Ахмадын баяр”-ын өдрийг тохиолдуулан байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудад болон сан хөмрөгч П.Ариунаад буцалтгүй тусламж олгох тушаал, хавсралтыг боловсруулж хянуулан баталгаажуулах ажлыг зохион байгуулсан. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.30 Биелэлтийн хувь: 100%

5.1.2.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ.	Тогтоол шийдвэр, төлөвлөгөөний хэрэгжилтийн тоо	1	1. 14 хоногийн ажлын биелэлт 2. Гуравдугаар улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, 3. Гуравдугаар улирлын гүйцэтгэлийн биелэлтийг файл болон цаасан хэлбэрээр менежерт хүлээлгэн өгсөн. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.30 Биелэлтийн хувь: 100%
5.1.3.	Музейн БНШК-ын хурлыг зохион байгуулж, данс бүртгэлийг батлуулна.	Боловсруулсан баримт бичгийн тоо	2	Музейн 2022 оны 2021 оны архивын баримтуудын данс бүртгэлийг хэлэлцэн батлав. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.27 Биелэлтийн хувь: 100%
5.1.4.	Гадны байгууллагаас ирсэн бичиг буюу edoc-т бүртгэлгүй албан бичгийг цахим системд бүртгэж, шийдвэрлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт	12	Тайлант хугацаанд гадны байгууллагаас ирсэн 12 бичгийг цахим системд бүртгэж, холбогдох албан тушаалтанд шилжүүлж, шийдвэрлэлтэд анхаарч ажиллаж байна. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.27 Биелэлтийн хувь: 100%
5.1.5.	2022 оны edoc-оор ирж буй албан бичгүүдийг хэвлэн гаргаж, “хуулбар үнэн” тэмдэгээр баталгаажуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт	Зааврын дагуу хөтлөн явуулна	Байгууллагад ирсэн бичиг 150 бичгийг хэвлэн гаргаж, “хуулбар үнэн” тэмдэгээр баталгаажуулж, менежерээр гарын үсэг зуруулж, баталгаажуулав. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.27 Биелэлтийн хувь: 100%

5.1.6.	Гадны байгууллагуудад edoc-оор илгээсэн бичиг бүрийг хэвлэмэл хуудсанд хэвлэж, дугаарлаж, албажуулан архивлах	Үйл ажиллагааны хэрэгжилт	Зааврын дагуу хөтлөн явуулна	Байгууллагаас явсан 113 албан бичгийг хэвлэмэл хуудасанд буулган, дугаарлаж, албажуулсан. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.27 Биелэлтийн хувь: 100%
5.1.7.	Архивын баримтыг холбогдох журам, стандартын дагуу хадгалах, хамгаалах	Үйл ажиллагааны хэрэгжилт	1	Архивын баримтыг холбогдох журам, стандартын дагуу хадгалж, хамгаалж байна. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.27 Биелэлтийн хувь: 100%
5.1.8.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт	1	Тус хууль тогтоомжуудыг хэрэгжүүлж ажиллаж байна. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.27 Биелэлтийн хувь: 100%

5.1.9.	Е-докоор ирсэн бичиг, явсан бичиг, өргөдөл гомдлын бүртгэл хөтөлж, хамаарах албан тушаалтад шилжүүлэх, шийдвэрлэлтэд анхаарч ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт	Зааврын дагуу хөтлөн явуулна.	UB ERP цахим системийн Е-докоор ирсэн бичгийг бүртгэж, хамаарах албан тушаалтад шилжүүлэх, мэргэжилтнүүдээс илгээх албан бичгийг бүртгэж, албажуулан илгээх, захиргаанд ирсэн өргөдөл гомдлын бүртгэл хөтөлж, холбогдох мэргэжилтнүүдээр шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.27 Биелэлтийн хувь: 100%
5.1.10.	Ирсэн бичиг бүртгэх, холбогдох албан тушаалтад шилжүүлэх, шийдвэрлэлтэд анхаарах	Үйл ажиллагааны хэрэгжилт	Зааврын дагуу хөтлөн явуулна.	Өссөн дүнгээр байгууллагад ирсэн бичиг нийт 150 байна. Судалж байгаа 1 бичиг, хугацаа хоцорч шийдвэрлэсэн, зөрчилтэй бичиг байхгүй. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.27 Биелэлтийн хувь: 100%
5.1.11	Явуулах бичгийг бүртгэж, илгээх	Үйл ажиллагааны хэрэгжилт	Зааврын дагуу хөтлөн явуулна.	Өссөн дүнгээр байгууллагаас нийт 113 албан бичиг явуулсан байна. Буцсан, зөрчилтэй бичиг байхгүй. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.27 Биелэлтийн хувь: 100%
5.1.12	Захирамжлалын тушаал А, Б хөтлөх, бүртгэх	Үйл ажиллагааны хэрэгжилт	Зааврын дагуу хөтлөн явуулна.	Өссөн дүнгээр нийт 81 тушаал гарсан. А тушаал 47, Б тушаал 34 гарсан байна. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.27 Биелэлтийн хувь: 100%

6. “Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх” зорилтын хүрээнд

6.1. Мэдлэг чадвараа дээшлүүлэх

6.1.1.	Засаг захиргааны байгууллагууд, бусад музей болон музейн мэргэжилтнүүдийн зохион байгуулсан хичээлд хамрагдана.	Танхимын болон цахим сургалтад хамрагдана.	-	<p>- Америкийн Монгол Судлалын төвөөс зохион байгуулж буй “Соёлын өв- Цуврал семинар”-аас зохион байгуулсан “Музейн ёс зүй” сургалтанд зоом-ээр оролцож тэмдэглэл хөтөлсөн. Уг сургалтанд ICOM-ийн ёс зүйн байнгын хорооны гишүүн Steph Scholten зочин илтгэгчээр оролцож ICOM-ийн 8 зарчмын зүйл заалтууд дээрээ жишээ авсан сургалт орсон.</p> <p>- БНСУ-ын Гүнжү их сургууль, МУ-ын ШУТИС-ийн хамтран хэрэгжүүлж буй "Монголын соёлын өвийн хадгалалт хамгаалалтын мэргэжилтний чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд сургалтанд хамрагдав.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.29 2022.08.22-2022.08.23</p> <p>Биелэлтийн хувь: 100%</p>
6.1.2	Улаанбаатар хотын түүх болон хувь хүний хөгжлийн холбогдолтой ном, бүтээл уншиж, тэмдэглэл хөтөлнө.	Ном уншиж, тэмдэглэл хөтөлнө.	-	<p>Үзмэрийн хадгалалт хамгаалалтын мэдлэгээ сайжруулахын тулд “Соёлын өвийг хамгаалах гарын авлага” 2, 3-р цувралуудыг уншиж тэмдэглэл хөтөлсөн.</p> <p>- Цуглуулгын эд зүйлсийг баримтжуулалт</p> <p>- Гар бичмэлүүдийг арчилж хамгаалах</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.05-2022.09.27</p> <p>Биелэлтийн хувь: 100%</p>
6.1.3.	Нийслэлийн дотоод аудитын албанаас зохион байгуулсан шилэн дансны шинэчилсэн систем нэвтрүүлэх, шилэн дансны мэдээ, мэдээллийн журмын төслийг боловсруулахад санал авах, сургалтанд хамрагдах	Онлайн сургалтанд хамрагдсан	1	<p>Шилэн дансны шинэчилсэн систем нэвтрүүлэх, шилэн дансанд байршуулах мэдээ, мэдээллийн журмын төслийн танилцуулга, санал авах, сургалтанд хамрагдсан.</p> <p>Биелэлтийн хувь: 100%</p>

6.1.4.	Засаг захиргааны байгууллагууд, бусад музейнүүд болон музейн мэргэжилтнүүдийн зохион байгуулсан сургалтад хамрагдана.	Хамрагдсан сургалтын тоо	1	Соёлын өвийн үндэсний төвөөс зохион байгуулагдсан “Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын технологи” сэдэвт бакалаврын хөтөлбөрийн цахим сургалтанд 3 ажилтныг хамруулсан. Эхэлсэн, дууссан огноо: 2022.09.27 Биелэлтийн хувь: 100%
6.1.5.	“Хүрээ хийдийн монгол зураг” судалгааны ажлын хүрээнд XVII-XX зууны эхэн үеийн Богдын хүрээний түүхийн холбогдолтой эх сурвалж, судалгааны ном, бүтээлүүдийг унших, судлах, тэмдэглэл хөтлөх	Уншиж судалсан эх сурвалж, ном, бүтээлийн жагсаалт	Үндэсний төв архивт сууж архивын баримтуудыг үзнэ.	Үндэсний төв архивт сууж V-VII Богдын түүхэнд холбогдох баримтуудыг шүүн авч үзэв. Мөн Лувсанцүлтэмжамцын бичсэн 8 Богдын намтар номыг уншиж, тэмдэглэл хөтлөв.

7. Нэмэлт ажлын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
7.1.	Үзмэрийг актаар хүлээлгэн өгч, хүлээн авах	-	Эрдэм шинжилгээний ажилтан О.Одсүрэнд “Үзмэр эд өлгийн зүйл, холбогдох баримт бичигтэй танилцах өргөдөл гаргасныг үндэслэн 2022 оны 08 сарын 31 өдөр “Музейн дотор үзмэр, эд өлгийн зүйл хүлээлцсэн акт” №07-г үйлдэн бичиг баримтын нэг дэсийн 1 ширхэг үзмэрийг хүлээлгэн өгч, хүлээн авсан. Эхэлсэн, дууссан огноо: 2022.08.31 Биелэлтийн хувь:100%
7.2.	Боловсролын ажилтаны ажлыг хүлээлцэх ажлыг зохион байгуулах	Менежер	Музейн захирлын 2022 оны 09-р сарын 05-ны өдрийн Б/34 тушаалаар боловсролын ажилтны ажил хүлээлцэх комиссыг бүртгэл мэдээллийн санч, дизайнер, тайлбарлагч нарын бүрэлдэхүүнтэй байгуулж, сан хөмрөгч Б.Төгсжаргалаас шинээр ажилд орж байгаа боловсролын ажилтан Г.Төгсжаргалд боловсролын ажилтны ажил хүлээлцсэн акт №06-г үйлдэн хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан. Эхэлсэн, дууссан огноо: 2022.09.05

			Биелэлтийн хувь:100%
7.3.	Сан хөмрөгийн өрөөнд шаардлагатай туслах хэрэглэгдэхүүний жагсаалт гаргаж үнийн судалгаа хийх	-	Сан хөмрөгийн өрөөнд шаардлагатай туслах хэрэглэгдэхүүний жагсаалтыг гаргаж, үнийн судалгааг бүртгэл мэдээллийн санч Ч.Өсөхжаргалтай хамт хийж, удирдлагад таницуулсан. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.30 Биелэлтийн хувь:100%
7.4.	Музейн үзүүллэгийн танхим дахь үзмэрийн цэвэрлэгээг хувиарын дагуу зохион байгуулна.	-	Сард нэг удаа зохион байгуулагддаг музейн үзүүллэгийн танхим дахь үзмэрийн цэвэрлэгээг үзмэр хянагч Л.Одмаа, тайлбарлагч Д.Дэлгэрмөрөн нартай хамтран төлөвлөгөөний дагуу нийт 2 удаа хийж гүйцэтгэсэн. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.30 Биелэлтийн хувь:100%
7.5.	Улаанбаатар мэдээ сонинг хэвлүүлэхэд бэлтгэж шивэх ажлыг хийнэ.	Эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр	Улаанбаатар мэдээ сонингийн 1985-1989 онуудын нийтлэл шивэх ажил явагдсаар байна. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.30 Биелэлтийн хувь:100%
7.6.	Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого явуулах	Нийслэлийн Засаг дарга	2022 оны 09 дүгээр сарын 05-аас 09 дүгээр сарын 30-ны хооронд Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй 5 дүүргийн нутаг дэвсгэр дэх 235 байршлын 473 тоо ширхэг үл хөдлөх дурсгалыг тооллогод хамруулж, дурсгалын солбицол тогтоох, гэрэл зураг авах, хадгалалт хамгаалалтын үнэлгээ хийх ажлыг зохион байгуулав.
7.7.	Хотын түүх, архитектурын чиглэлээр зөвлөгөө өгөх	Г.Очбаяр	2022.08.31-нд Герман Улсын Бонны их сургуулийн Урлагийн сургуульд докторантаар суралцаж Болормаад Улаанбаатар хотын орон зайн төлөвлөлт, барилга архитектур, чимэглэлд туссан үндэсний баримал, чимэглэлийн талаар зөвлөгөө өгөв.
7.8.	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогын бэлтгэл ажлыг хангах	Нийслэлийн соёл, урлагийн газар	2022.08.12-31-нд Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогыг 09.05-10.01-ний хугацаанд зохион байгуулахаар төлөвлөж, Нийслэлийн соёл, урлагийн газартай хамтран тооллогын багийн бүрэлдэхүүн, тооллогод шаардагдах төсөв, тоног төхөөрөмжийн судалгаа, тооллого хийх хуваарь зэргийг гаргаж, бэлтгэл ажлыг зохион байгуулав.

7.9.	Улаанбаатар хотын түүх, соёлын үл хөдлөх дурсгалын цахим мэдээллийн сангийн вэб сайтыг шинэчлэх төсөл хэрэгжүүлэх	Г.Очбаяр	2022.08.31-нд Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын цахим мэдээллийн санг 2018 онд Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр бий болгосон бөгөөд өдгөө энэхүү цахим сан байршиж буй www.ubheritage.mn сайтыг бүрэн шинэчлэх ажлыг эхлүүлээд байна. Уг сайтыг шинэчлэх төслийг бичиж дуусгасан ба төслийг санхүүжүүлэгч байгууллагад танилцуулах бэлтгэл ажлыг Тунгаахуй ТББ-тай хамтран зохион байгуулж байна.
7.10.	Нийтлэл хэвлүүлэх	Г.Очбаяр	2022.09.04-нд Visit Mongolia аппликейшнд Улаанбаатар хотын түүхэн дэх онцлох үйл явдлууд нийтлэл, музейн сурталчилгаа 7 хэлээр орчуулагдан нийтлэгдэв.
7.11.	Ажилтан, албан хаагчдыг салбарын болон дээд байгууллагын шагналд тодорхойлох ажлыг зохион байгуулах	-	Музейн хамт олны 2022 оны 01 дүгээр хурлаар Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 383 жилийн өдрийг тохиолдуулан салбарын болон дээд байгууллагын шагналд 6 ажилтныг шагнуулахаар нэр дэвшүүлэн, 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 113 тоот албан бичгээр Нийслэлийн Соёл, Урлагийн газарт холбогдох материалыг хүргүүлсэн. Эхэлсэн, дууссан огноо: 2022.07.01-2022.09.30 Биелэлтийн хувь: 100%

ХЯНАСАН:
ЗАХИРАЛ

П.ДАВААСҮРЭН

НЭГТГЭСЭН:
МЕНЕЖЕР /ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ/

С.ЭРДЭНЭБАТ